

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэн нь 1968 онд үүсэн байгуулагдсан цагаасаа Дорно дахин судлал, тэр дундаа Хятад судлалын чиглэлээр судалгаа явуулж ирсэн уламжлалтай билээ. Ч.Далай, Л.Жамсран, Г.Сүхбаатар тэргүүтэй тус хүрээлэнгийн Хятад судлалын салбарын нэрт эрдэмтэд Хятад орон судлалын талаар жинтэй бүтээл туурвихын зэрэгцээ Монгол, Хятад хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг тодлон судалж, Монгол Улсын эрт, дундад үеийн түүх, соёлын судалгааг өргөн хүрээнд явуулж байв. Өдгөө ч Хятад судлал нь тус хүрээлэнгийн судалгааны үндсэн чиглэлийн нэг хэвээр байна.

Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд заасанчлан ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны эн тэргүүний зорилт болох тул тус улстай тогтоосон Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг бүх талаар хөгжүүлэх, түүний шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулахад тус хүрээлэнгийн Хятад судлалын салбарын эрдэмтэд зохих хувь нэмрээ оруулсаар байна.

“Бид бол олон мянганы түүхэн харилцаатай, уул, усаар холбогдсон мөнхийн хөрш орнууд” хэмээн Хятадын эрдэмтэд, улс төрчид туурвисан бүтээл, хэлсэн үгэндээ олонтоо тэмдэглэсэн байдаг билээ. Үнэхээр ч Монгол, Хятадын ард түмний харилцаа нь олон мянганаар хэмжигдэх баялаг түүхтэй юм. Энэхүү баялаг түүхийн нэгээхэн чухал хэсэг нь хоёр улсын шинэ үеийн харилцааны түүх бөгөөд 2019 онд Монгол Улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн билээ.

Энэ хүрээнд манай хүрээлэн 2000 оноос хойш жил бүр уламжлал болгон явуулж байсан “Олон улс судлал” эрдэм шинжилгээний хурлаа сэргээх, чингэхдээ Монгол Улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн он хүрээнд “Олон улс судлал: Монголын Хятад судлал” сэдвээр зохион байгуулахаар тогтсон юм. Гэвч олон улсад үүсэн цар тахлын улмаас хойшлогдож, 2020 онд цахимаар зохион байгуулсан болно.

“Олон улс судлал 2020: Монголын Хятад судлал” эрдэм шинжилгээний хуралд Хятад судлал бүхий Монгол Улсын шинжлэх ухааны голлох байгууллагууд болох Стратеги судалгааны хүрээлэн, Аюулгүй байдал судлалын хүрээлэн, ШУА-ийн Философийн хүрээлэн, Хэл зохиолын хүрээлэн, Батлан хамгаалахын эрдэм

шинжилгээний хүрээлэн зэрэг эрдэм шинжилгээний хүрээлэн, төв, Монгол Улсын Их Сургууль, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Дотоод Хэргийн Их Сургууль, Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулийн эрдэмтэн багш нарын төлөөлөл оролцсон юм.

Тус хуралд оролцсон эрдэмтэд БНХАУ-ын улс төр, гадаад бодлого, аюулгүй байдал, эдийн засаг, шашин гүн ухаан, Монгол-Хятадын харилцаа, түүх, улс төр, эдийн засаг болон шинжлэх ухаан, боловсролын харилцаа гэсэн ерөнхий 4 чиглэлийн хүрээнд 20 гаруй илтгэл тавьж, хэлэлцүүлэг зохион байгуулсныг бүрнээр эмхэтгэн гаргаж байна.

“Олон улс судлал 2020: Монголын Хятад судлал” эрдэм шинжилгээний хурал нь Монгол Улсад Хятад судлалыг хөгжүүлэх, тулгамдаж буй асуудлаа хэлэлцэх хүрээнд эрдэмтэн судлаачид судалгааны үнэтэй санал, дүгнэлт дэвшүүлж, чөлөөт хэлэлцүүлэг өрнүүлэн мэдээлэл солилцсон үр дүнтэй арга хэмжээ болсныг энд онцлон тэмдэглэе.

Энэхүү эмхэтгэлд тусгасан эрдэмтдийн судалгааны санал дүгнэлт нь хувь судлаачдын байр суурь бөгөөд Монголын Хятад орон судлалын нэгэн үеийн хөгжлийг төвшинг илтгэн харуулахуйц бүтээлүүд багтсан болохыг онцолж байна. Цаашид тус хүрээлэнгээс “Олон улс судлал” эрдэм шинжилгээний хурлыг жил бүр орон судлалын тодорхой чиглэлд хандуулан тогтмолжуулан зохион байгуулж байхаар төлөвлөж байгаагаа Та бүхэнд дуулгахдаа таатай байна.

Энэхүү эрдэм шинжилгээний хурлыг цахимаар зохион байгуулахад ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Хятад судлалын салбарын эрдэмтэн судлаачид голлох үүрэгтэй оролцсон болно. Энэ ташрамд тус эрдэм шинжилгээний хурлыг санаачлан удирдлагаар хангаж ажилласан хүрээлэнгийн захирал, доктор, дэд профессор Д.Золбоо, илтгэлээ хэлэлцүүлж оролцсон нийт эрдэмтэн судлаачид, хурлын үйл ажиллагаанд үг хэлж дэмжиж оролцсон ШУА-ийн Тэргүүн дэд ерөнхийлөгч, академич Г.Чулуунбаатар, ГХЯ-ны Хөрш орнуудын газрын захирал Т.Батцэцэг, эмхэтгэн хэвлүүлэх ажлыг хариуцаж ажилласан эрдэм шинжилгээний ажилтан Ш.Догмийчойдон, Б.Баяржаргал, хянан нягталсан доктор Д.Шүрхүү болон “Бэмби сан” хэвлэлийн газрын хамт олонд гүн талархал илэрхийлж байна.

Монголын олон улс судлал бадран хөгжиж, эрдэм бүтээл ундарч байх болтугай.

*Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэнгийн
Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор Раднаасэдийн ТӨРДАЛАЙ*